



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №10

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусын шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Дани, Швед, Того улсын газар нутаг зэрлэг болон тэжээвэр шувуудын дунд илэрсэн байна (Хүснэгт 1. Зураг 1. Шувууны томуугийн А хүрээний вирусын тархалт болон вирусын хэлбэр).

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна. Энэтхэг улсын Харяна мужийн Гургаон хотод 11 настай хүүхдэд ханиадны шинж тэмдэг илэрч, эмчлэгдэж байгаад 2021 оны 07 сарын 12 нд нас барсан. Өвчтөнөөс шинжилгээ авахад Томуугийн А хүрээний H5 болон В вирусийн хэв шинж илэрсэн. Хүүхэд халдвар авсан бүс нутагт өвчний сэжигтэй, үхсэн шувууд бүртгэгдээгүй. Хүүхдийг ойрын хавьтал, эмч, сувилагч нарын дунд өвчний шинж тэмдэг илрээгүй байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн 4 тохиолдол бүртгэгдсэн. БНХАУ-н Сичуан аймгийн Сюаньхань мужид 51 настай эмэгтэй 6-р сарын 25 нд өвчний шинж тэмдэг илэрч, эмчлэгдэж байгаад 7-р сарын 4 нд нас барсан. 2 дахь тохиолдол мөн улсын Кайцзян мужийн 57 настай эрэгтэй 6-р сарын 22 нд өвчний шинж тэмдэг илэрч, эмнэлэгт 7-р сарын 5 нд хэвтэн эмчлэгдэж байна. Өвчний биеийн байдал хүнд. Шинж тэмдэг илрэхээс өмнө шувууны аж ахуйд ажилласан. БНХАУ-н Туннань дүүрэгт 57 настай эрэгтэй 6-р сарын 23 нд өвчний шинж тэмдэг илэрч, эмнэлэгт 6-р сарын 30 нд хэвтэн эмчлэгдэж байна. Өвчний биеийн байдал хүнд. Шинж тэмдэг илрэхээс өмнө шувууны аж ахуйд ажилласан. Сичуан аймгийн Бачжоу мужид 55 настай эрэгтэй 6-р сарын 30 нд өвчний шинж тэмдэг илэрч, эмнэлэгт 7-р сарын 4 нд хэвтэн эмчлэгдэж байна. Өвчний биеийн байдал хүнд.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H7N9 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H9N2 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

ДОЛОО. Шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.


ДОЛОО. 2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон шувууны мэдээлэл:

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусын тархалт болон вирусын хэлбэр

№	Мэдээлсэн өдөр	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Дэд хэвшинж	Улс	Муж	Өртсөн нийт хүн, шувуудын тоо	Тайлбар
1	7/20/2021	7/12/2021	H5N1	Энэтхэг	Харяна	1	12 настай хүү
2	7/16/2021	6/7/2023	H5N6	БНХАУ	Сичуан	1	55 настай эрэгтэй
3	7/26/2021	4/7/2023	H5N6	БНХАУ	Сичуан	1	51 настай эмэгтэй
4	7/26/2021	4/7/2023	H5N6	БНХАУ	Сичуан	1	57 настай эрэгтэй
5	7/26/2021	4/7/2023	H5N6	БНХАУ	Сичуан	1	66 настай эрэгтэй
6	7/8/2021	7/4/2021	H5N8	Дани	Иллэр тосгон	38000	Тахиа
7	7/8/2021	3/2/2021	H5N4	Швед	Солвесбург хот	1	Цагаан шонхор
8	7/8/2021	1/6/0121	H5N1	Того	Жагбли	2000	Тахиа

Эх сурвалж: www.poultrymed.com, Cidrap.umn.edu

(Зураг 1) 2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусын тархалт, Монгол орныг дайран өнгөрөх нүүдлийн шувуудын томоохон замууд /зургаар/



ДОЛОО. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:

2021 оны 06-р сарын 30 наас 07-р сарын 26 ны хооронд шувууны томуугийн өвчлөлийн сэжигтэй, үхсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.